

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жамсран	Дугаар	L297
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Цагаан-Үүр сум
Төрсөн газар	Цагаан-Үүр сум	Төрсөн он	1924
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уйлганы хурал	Сүм хийдийн дугаар	ХӨЦҮ 052
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны6-р сарын 14	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Уйлганы хурал

Мөнхбат: Тэгэхээр таныг одоо хүүхэд ахуй цагт байх үед энэ Уйлганы хурал хичнээн дугантай, дуганы хэмжээ одоо ямар хэмжээний, тийм том жижгийн хувьд ямар дугантай байсан юм бол оо?

Жамсран: Овоо томоохон л дуган байсан юм.

Мөнхбат: Хоёр дуган байсан гэдэг үү?

Жамсран: За нэг нь жижигхэн юм байсан юм аа.Нэг нь томоохон дуган байсан юм. Жижигхэндээ хэн мэдэхэв, ямар ч янзын юм байсан юм. Уйлганы хурал гэж л байсан юм.

Мөнхбат :Даяндээрхийн хүрээнээс гарч салбарласан?

Жамсран: Дээрхийн хүрээнээс л одоо гарч салбарлаж энд хүрч ирж цаг цагийн хурал гэж байсан юм.

Мөнхбат: Лам нар нь одоо ээлжилж гарч ирдэг?

Жамсран: Аа бөөнөөрөө л ер нь давхиад л гараад ирдэг байсан юм байх, мориор.

Мөнхбат: Нэг гарч ирэхдээ ер нь хэдэн лам хурдаг байсан юм бол?

Жамсран: За чухам мэдэхгүй дээ. Олуулаа л хурж байсан байх, нэлээн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Тэгэхээр та хэллээ ш дээ, гучин дөрөв таван оны үед ер нь хаагдаад л дахиад хурал хурахаа байсан гэж тийм үү?

Жамсран: Тийм, гучин дөрөв таван оны үед л хаагдчихсан байх. Тэгээд гучин долоо, найман онд энэ Даяндээрх буучихсан байх үед энэ малын хураалт явж. Улсуудыг авч явж байх үед л би хураалтны мал цуглуулж л арван дөрвөн настай хүү л давхиж явсан юм даг.Тэгэхэд минь л дотор нь сарлагийн бүх байж байсан юм.

Мөнхбат: Хэдийгээр хаагдаад одоо гурав дөрвөн жил болсон ч гэсэн дуган бол одоо бүтнээрээ шахуу одоо ямар ч гэсэн тэр дөрвөн хана нь байж байсан юм байна, тийм ээ?

Жамсран: Дөрвөн хана нь , дээвэр нь байсан юм.

Мөнхбат: За дотор нь байсан тэр одоо бурхан тахил ном судрууд бол байхгүй болсон?

Жамсран: Аа тэрийг тэр Дээрхийн хүрээ рүү зөөчихсөн байсан байх.

Мөнхбат: Дээрхийн хүрээ рүү зөөчихсөн байсан байх?

Жамсран: Тийм.

Мөнхбат :Ер нь нутгийн хөгшчүүл бол хэдий олон жил болж байгаа гэж ярьдаг байсан юм бол, энэ дуганы нас сүүдрийг одоо. Ямар ч байсан Даяндээрхийн хүрээний салбар болохлээр одоо Даяндээрхийн хүрээнээс бол хойш байгуулагдсан нь ойлгомжтой тийм ээ?

Жамсран: Хойхно л байгуулагдаа байх гэж л би боддог юм.

Мөнхбат :Тэгээд л нөгөө гучин долоо найман оны үед тэгээд л балгас болсоор байгаад дууссан?

Жамсран: Тийм, гучин таван он, дөрвөн оны үед л хаагдаж балгас болсон байх. Тэр Хатуу лугалааны үе гээд ярилцдаг юм аа.Артел коммун болно гээд баахан нэг юм болж эхэлсэн юм.Тэр үед л нурчихсан юм даг.

Мөнхбат: Тэгэхээр ямар шүтээн сахиус сахидаг байсан юм, энэ талаар одоо юм...?

Жамсран: Тэр шүтээн байхгүй. Зүгээр хурал л байсан.

Мөнхбат :Гол шүтээн нь Даяндээрхийнхээ хүрээн дээр?

Жамсран: Хүрээн дээрээ байсан.Уйлганыхаа хурал л гэж ингэж хэлж байсан юм.

Мөнхбат: Энэ ямар өдрүүдэд хурдаг байсан юм бол, голдуу? Ямар цагаар?

Жамсран: За тэр хурдаг цагийг мэдэхгүй байна. Зун нэг хурдаг , намар нэг хурдаг байсан юм гэж ярилцдаг байсан юм билээ.

Мөнхбат :Нөгөө дүйчэн онцгой өдрүүддээ л хурдаг байж дээ, тийм ээ?

Жамсран:Тийм.

Мөнхбат :Ямар ямар голдуу хурал хурж, ном уншлага уншдаг байсан юм бол?

Жамсран: За тэрийг би мэдэхгүй ээ.

Мөнхбат :За таньд баярлалаа. Ингээд Уйлганы хүрээний талаар өөрт байгаа мэдээллээ дамжуулсанд талархал илэрхийлэе.Таны өгсөн мэдээлэл манай судалгааны багт үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа.